

**Халдвартын эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил**

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
  - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (A.)
  - Зөв, Зөв, Буруу (B.)
  - Зөв, Буруу, Буруу (C.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (E.)

**Сонгогдсон сорил**

/1./ БЦЖ вакцин гэж юу вэ ?

- A. Сүрьеэгийн үхсэн савханцар
- B. Хоруу чанаргүй сүрьеэгийн амьд савханцар
- C. Сүрьеэгийн савханцарын хор
- D. Сүрьеэгийн савханцарын эд эсийн хэсэг
- E. Бүрэн бус антиген

/2./ Цэрний түрхэцийн шинжилгээний хариунд эерэг ба /++/ гэсэн тэмдэглэл байвал харах талбайд хэдэн ширхэг хүчилд тэсвэртэй нян (ХТН) илэрсэн бэ?

- A. ХТН олдоогүй /100 ХТ
- B. 1-9 ХТН/ 100 ХТ
- C. 10-99 ХТН/ 100 ХТ
- D. 1-10 ХТН/ 50 ХТ
- E. 10 дээш ХТН/ 20 ХТ бүрт

/3./ Чихрийн шижин өвчинтэй 50 настай эмэгтэйд халуурах шинж гэнэт илэрсэн байна. Гэрлийн шинжилгээнд зүүн уушгины дээд дэлбэнд нэвчдэст өөрчлөлт тодорхойлогдсон бол цаашид оношийг тодруулахад ямар шинжилгээг заавал хийх ёстой вэ?

- A. Гуурсан хоолой дурандах
- B. Сүрьеэгийн нян цэрэнд хайх
- C. Амьсгалын багтаамж шалгах шинжилгээ
- D. Цусны шинжилгээ
- E. Туберкулины сорил

/4./ Өвчтөний хожимдолыг багасгахын тулд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол хийх
- B. Хүн амын дунд сүрьеэ өвчний талаар сургалт, сурталчилгаа тогтмол хийх
- C. Жил бүр туберкулины сорил тавьж халдварын тархалтыг тогтоох
- D. Эмч, эмнэлгийн ажилтаны дунд тогтмол урьдчилан сэргийлэх үзлэг хийх
- E. Дээрхи бүгд

/5./ Глюкокортикоид гормон удаан хугацаагаар хэрэглэсний улмаас сүрьеэ үүсдэг шалтгаан бол:

- A. Уг гормон Т эсийн идэвхийг бууруулна
- B. Эсрэг биет үүсэх процессыг дарангуйлна
- C. Махбодоос Са гадагшлуулалтыг нэмэгдүүлнэ
- D. Фагоцитозын идэвхи дарангуйлна

- Е. Зөв хариулт бол: А, В, D, юм.
- /6./ Анхдагч сүрьеэгээр голдуу ямар насныхан өвчилдөг вэ?
- А. Өндөр настангууд
  - В. Бага насны болон өсвөр насны хүүхэд
  - С. Залуу насныхан
  - D. Идэр насныхан
  - Е. Дээрхи бүгд
- /7./ Туберкулем голдуу хаанаас задардаг вэ ?
- А. Төвөөс
  - В. Захаас
  - С. Ирмэгээс
  - D. Зах ирмэгдүү, гадагшлуулагч бронх байгаа хэсгээс
  - Е. Дээрхи бүгд
- /8./ Туберкулины сорилыг хаана хийх вэ?
- А. Арьсан дотор
  - В. Арьсан дор
  - С. Булчинд
  - D. Судсанд
  - Е. Дээрхи бүгд
- /9./ Уушгины хоёрдогч сүрьеэгийн үед цээжний гэрлийн шинжилгээнд үрэвслийн өөрчлөлт голдуу хаана байрладаг вэ?
- А. I, II, VI сегмент
  - В. VIII, IX, X сегмент
  - С. IV, V сегмент
  - D. III сегмент
  - Е. Дээрхи бүгд
- /10./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?
- А. Уушигны цэр эерэг сүрьеэтэй өвчтөн
  - В. Уушигны цэр сөрөг сүрьеэтэй өвчтөн
  - С. Уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн
  - D. Уушигны сүрьеэ бусад эрхтэний сүрьеэтэй хавсарсан тохиолдол
  - Е. Дээрхи бүгд
- /11./ Сорвит хөндийт сүрьеэтэй өвчтөний нас баралтын гол шалтгааныг нэрлэнэ үү?
- А. Сүрьеэгийн хордлого
  - В. Уушгины цус алдалт
  - С. Дотор эрхтэний амилоидоз
  - D. Бусад эрхтэний сүрьеэ хавсрах
  - Е. Архаг уушгин- зүрх
- /12./ Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн, эмчилгээний нэгдүгээр бүлгээр бүрэн эмчлэгдсэн ба хяналтын 5 дахь сарын цэрний түрхэцийн шинжилгээг хийлгээгүй бол эмчилгээний үр дүнг юу гэж тооцох вэ?
- А. Эмчилгээ дууссан
  - В. Үр дүнгүй эмчлэгдсэн
  - С. Эдгэрсэн
  - D. Дахисан
  - Е. Дээрхи бүгд
- /13./ Уушигны голомтот сүрьеэгийн тодорхойлолтыг бичнэ үү?
- А. Уушигны сүрьеэгийн хязгаарлагдсан өөрчлөлт юм
  - В. Эмнэл зүйн шинж тэмдэггүй явцтай уушигны сүрьеэгийн хэлбэр юм
  - С. Уушигны хоёрдогч сүрьеэгийн хэлбэр
  - D. Нэг юмуу хоёр талын уушигны нэгээс хоёр сегментийг хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй сүрьеэгийн голомтот өөрчлөлт үүснэ
  - Е. Дээрхи бүгд
- /14./ Хөндийг бүрэн эдгэрсэн гэж хэзээ тооцох вэ ?
- А. Хоёрдогч киста үүсэх
  - В. Псевдотуберкулем үүсэх

- C. Сорвижих
  - D. Ариутгагдсан хөндий үүсэх
  - E. Дээрхи бүгд
- /15./ Уушгины сүрьеэгийн цэр “эерэг” тохиолдол гэж хэзээ тооцох вэ?
- A. 2 удаагийн цэрний түрхцэнд эерэг хариутай бол
  - B. 2 удаагийн цэрний түрхцэнд сөрөг ч, өсгөвөрлөх шинжилгээнд эерэг хариутай бол
  - C. 2 удаагийн цэрний түрхцэнд сөрөг ч, цээжний гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн өөрчлөлттэй бол
  - D. 2 удаагийн цэрний түрхцэнд сөрөг ч, сүрьеэгийн эмнэл зүйн шинж илэрсэн бол
  - E. Дээрхи бүгд
- /16./ Сүрьеэгийн хагас идэвхитэй илрүүлэлтэнд хамрагдах хүрээг тодорхойлно уу?
- 1. Сүрьеэтэй өвчтөний хавьтал
  - 2. Гэр оронгүй хүмүүс
  - 3. Хоригдол
  - 4. Оюутнууд
  - 5. Залуус
- /17./ Доорхоос ямар тохиолдолд олон эмэнд дасалтай сүрьеэ гэж үзэх вэ?
- A. Изониазидад дасалтай
  - B. Изониазид+ рифампицинд дасалтай
  - C. Пиразинамид+ этамбутолд дасалтай
  - D. Изониазид болон стрептомицинд дасалтай
  - E. Дээрхи бүгд
- /18./ Сүрьеэгийн тохиолдлыг илрүүлэх идэвхитэй илрүүлэлтэнд хэрэглэдэг гол шинжилгээний аргыг нэрлэнэ үү?
- A. Цэрний түрхэцийн шинжилгээ
  - B. Цээжний гэрлийн шинжилгээ
  - C. Туберкулины сорил
  - D. Цусны шинжилгээ
  - E. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- /19./ Сүрьеэгийн плеврит гэж юу вэ ?
- A. Цээжний гялтан хальсны үрэвсэл
  - B. Цээжний гялтан хальсны өвөрмөц үрэвсэл
  - C. Сүрьеэгийн нянгаар үүссэн хуурай ба шүүдэст цээжний гялтан хальсны өвөрмөц үрэвсэл
  - D. Сүрьеэгийн нянгаар үүссэн цээжний гялтан хальсны үрэвсэл
  - E. Дээрхи бүгд
- /20./ Архаг архичин сүрьеэтэй тохиолдлын эмчилгээнд анхаарах зүйлсийг тоочно уу?
- A. Эмийг өдөр бүр харж уулгах
  - B. Элэгний үйл ажиллагааг шинжилгээгээр хянах
  - C. Эмнэлэгт хэвтүүлж эмчлэх
  - D. B” төрлийн витамин уулгах
  - E. Дээрхи бүгд
- /21./ Уушигны хоёрдогч сүрьеэгээс элбэг тохиолдох хэлбэрийг нэрлэнэ үү?
- A. Уушигны голомтот сүрьеэ
  - B. Уушигны нэвчдэст сүрьеэ
  - C. Уушигны туберкулема
  - D. Уушигны хөндийт сүрьеэ
  - E. Сорвит хөндийт сүрьеэ
- /22./ БЦЖ вакциныг хаана тарих вэ ?
- A. Арьсан дотор
  - B. Арьсан дор
  - C. Судсанд
  - D. Арьсан дээр
  - E. Булчинд
- /23./ Эмч хариуцсан өрхөөр явж цэрний сорьц цуглуулан сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг хэрэглэсэн бэ?

- A. Идэвхитэй илрүүлэлт
  - B. Идэвхигүй илрүүлэлт
  - C. Хагас идэвхитэй илрүүлэлт
  - D. Идэвхигүй болон идэвхтэй илрүүлэлт
  - E. Хагас идэвхитэй болон идэвхгүй илрүүлэлт
- /24./ Сүрьеэтэй жирэмсэн тохиолдлын эмчилгээнд эсрэг заалттай сүрьеэгийн эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү ?
- A. Этамбутол
  - B. Стрептомицин
  - C. Пиразинамид
  - D. Изониазид
  - E. Рифампицин
- /25./ Анхдагч сүрьеэгийн үед илэрч болох салст цочрох урвалын шалтгааныг тайлбарлана уу?
- A. Салстанд сүрьеэгийн өвөрмөц үрэвсэл үүснэ
  - B. Сүрьеэгийн нянгийн хооронд салст чочирч харшилын урвал үүснэ
  - C. Сүрьеэгийн нян цусаар тархаж эргэлдэнэ
  - D. Сүрьеэгийн нян тунгалгаар тархаж эргэлдэнэ
  - E. Дээрхи бүгд
- /26./ Туберкулемын тогтвортой явцын үед цусны шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ ?
- A. СОЭ хурдсах, лейкоцитоз, лейкоцитын цөм зүүн тийш хазайсан
  - B. СОЭ хэвийн, лейкоцитоз, лейкоцитын цөм зүүн тийш хазайсан
  - C. Онцын өөрчлөлт илрэхгүй
  - D. Лейкоцитоз, лимфоцитопения, СОЭ хурдсах
  - E. Дээрхи бүгд
- /27./ Уушигны гэрлийн шинжилгээнд болон эмнэл зүйд гуурсан хоолойн гаралтай киста сүрьеэгийн хөндийгөөс хэрхэн ялгагдах вэ?
- A. Шинж тэмдэггүй, зузаан ханатай цагираг сүүдэр, орчны эд өөрчлөлтгүй
  - B. Хордлогын хам шинж бага илэрсэн, нимгэн ханатай цагираг сүүдэр, орчны эд өөрчлөлттэй
  - C. Шинж тэмдэггүй, нимгэн ханатай цагираг сүүдрүүд орчны эдийн өөрчлөлтгүй.
- /28./ Рифампицины гол гаж нөлөөг нэрлэнэ үү?
- A. Элэгний үрэвсэл
  - B. Анемия
  - C. Захын мэдрэлийн үрэвсэл
  - D. Харааны мэдрэлийн үрэвсэл
  - E. Үе өвдөх
- /29./ Өрхийн эмч сүрьеэтэй өвчтөний хавьталуудын дунд урьдчилан үзлэг хийж хүүхдийн сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн бол илрүүлэлтийн ямар аргыг ашигласан бэ?
- A. Идэвхитэй
  - B. Идэвхигүй
  - C. Хагас идэвхитэй
  - D. Идэвхитэй болон хагас идэвхитэй аргуудыг хослуулсан
  - E. Дээрхи бүгд
- /30./ Плеврийн хальс руу сүрьеэгийн халдвар хаанаас голдуу дамжин орох вэ?
- A. Гуурсан хоолойн өвөрмөц үрэвсэлийн голомтоос
  - B. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн өөрчлөлтөөс
  - C. Бусад эрхтэний сүрьеэгийн өөрчлөлтөөс
  - D. Уушгинд өнгөц байрласан сүрьеэгийн голомт шууд цоорсноос
  - E. Зөв хариулт бол: B ба D юм
- /31./ 136Этамбутолын эсрэг заалтыг нэрлэнэ үү?
- A. Харааны мэдрэлийн үрэвсэлтэй тохиолдол
  - B. Элэгний үрэвсэлтэй тохиолдол
  - C. Захын мэдрэлийн үрэвсэлтэй тохиолдол
  - D. Бөөрний үрэвсэлтэй тохиолдол

Е. Дээрхи бүгд

/32./ Уушигны голомтот сүрьеэгийн үед бодит үзлэгт ямар өөрчлөлтүүд илрэх вэ ?

1. Цээжний хэнхэрцэг өөрчлөлтгүй
2. Тогшилтоор болон чагналтаар онц өөрчлөлтгүй
3. Цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно
4. Их хэмжээний хуурай нойтон хэржигнүүр сонсогдоно
5. Цээжний хэнхэрцэг торх хэлбэртэй болсон байна

/33./ Мантугийн сорилын хариу урвалыг хэдэн цагийн дараа хэмжиж тодорхойлох вэ ?

1. 24 цаг
2. 72 цаг
3. 12 цаг
4. 48 цаг
5. 2 цаг

/34./ Анхдагч сүрьеэгийн эмнэл зүйн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Сүрьеэгийн хордлого
2. Сүрьеэгийн бронхаденит буюу цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
3. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
4. Нэвчдэст сүрьеэ
5. Хөндийт сүрьеэ

/35./ Сүрьеэгийн нянг устгах ариутгалын уусмалыг нэрлэнэ үү?

1. Хлорамины уусмал
2. 5% фенол
3. Спирт
4. 2% лизол
5. Давсны хүчил

/36./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү?

1. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал
2. Туберкулины сорил 10 мм-ээс дээш эерэг урвалтай
3. Бусад шинжилгээ болон эмнэл зүйд сүрьеэ үгүйсгэгдсэн
4. Туберкулины сорилд эерэг гарсан бүх тохиолдол
5. Гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн бага зэргийн өөрчлөлттэй

/37./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?

1. Шууд хяналттай эмчлэх
2. Үр дүнгийн хяналт хийх
3. Гаж урвалын хяналт хийх
4. Биеийн жингийн хяналт
5. Цусны ерөнхий шинжилгээ хийх

/38./ Сүрьеэгийн бронхаденитыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү ?

1. Лимфийн хавдрууд (лимфогрануломатоз, лимфосаркома, лимфолейкоз)
2. Төвийн гаралтай хорт хавдар
3. Өвөрмөц бус лимфаденопатии (корь, коклюш, вирусн халдварт өвчин г.м)
4. Уушигны голомтот хатгалгаа
5. Улаан хоолойн хавдар

/39./ Уушигны голомтот сүрьеэтэй шинэ тохиолдлыг эмчлэх эмчилгээний бүлэг, хугацааг сонгоно уу?

1. Нэгдүгээр бүлэг, 4 сар
2. Хоёрдугаар бүлэг, 8 сар
3. Хоёрдугаар бүлэг, 6 сар
4. Гуравдугаар бүлэг, 6 сар
5. Гуравдугаар бүлэг 4 сар

/40./ Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 настай хүүхдэд Мантугийн сорил тавьж, 72 цагийн дараа хариуг шалгахад 6 мм хэмжээтэй гүвдрүү жижиг

цэврүүний хамт үүссэн бол энэ урвалыг юу гэж дүгнэх вэ? Цаашид авах арга хэмжээг тодорхойлоно уу?

1. Эерэг урвал
2. Эмнэл зүйн шинжүүд болон бодит үзлэгийн өөрчлөлтийг шалгана
3. Цээжний гэрлийн шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно
4. Цусны ерөнхий шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно.
5. Эмнэл зүй болон бусад шинжилгээнд сүрьеэгүй нь батлагдсан бол химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.

/41./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн клиник-рентгены хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Бага хэлбэр
2. Нэвчдэст хэлбэр
3. “Хавдар” төст хэлбэр
4. Шинж тэмдэггүй хэлбэр
5. Хүндрэлтэй хэлбэр

/42./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгүүдийг тоочно уу?

1. 21 хоногоос дээш хугацаанд ханиах
2. Цэр, цустай цэртэй ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурах, хөлрөх
5. Турах

/43./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Цэртэй ханиах, цустай ханиах
2. Хордлогын хам шинж тод илрэх
3. Цэрний түрхэц эерэг гарах
4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч, СОЭ хурдсах
5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/44./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг тоочно уу?

1. 14 хоногоос дээш хугацаагаар ханиах
2. Цэртэй, цустай ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурч, хөлрөх
5. Турах

/45./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн үед бодит үзлэгээр илрэх өөрчлөлтийг бичнэ үү?

1. Эгэмний дээд хэсэгт тогшилтын чимээ бүдгэрнэ
2. Далны хооронд тогшилтын чимээ бүдгэрнэ
3. Эгэмний дээд хэсэгт жижиг нойтон хэржигнүүртэй
4. Чагнахад онцын өөрчлөлтгүй
5. Тогшилтоор өөрчлөлтгүй

/46./ Казеоз хатгалгааны үед илрэх үндсэн шинжийг бичнэ үү?

1. Хурц эхлэл
2. Өндөр халуурах
3. Цэртэй, цустай цэртэй ханиах
4. Нойтон хэржигнүүр их хэмжээгээр сонсогдох
5. Хуурай ханиах

/47./ Уушигны гэрлийн шинжилгээнд тархмал сүүдрийн хам шинж ямар өвчнүүдийн үед илэрч болох вэ?

1. Уушигны милиар сүрьеэ
2. Хорт хавдарын метастаз
3. Уушиг тоосжих өвчин
4. Зогсонгишлын уушиг

5. Уушгины жижиг голомтот хатгалгаа
- /48./ Элгэнд хортой гаж урвал үүсгэх боломжтой сүрьеэгийн эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?
1. Изониазид
  2. Рифамицин
  3. Пиразинамид
  4. Этамбутол
  5. Стрептомицин
- /49./ БЦЖ вакцин хийх заалтыг нэрлэнэ үү?
1. Туберкулины сорилд эерэг хүүхэд
  2. Бага насны хүүхдэд
  3. Бүх насны хүүхдэд
  4. Гүйцэд, эрүүл нярай хүүхдэд
  5. Сүрьеэгээр өвчлөөгүй хүүхэд
- /50./ Орчин үеийн сүрьеэгийн эмчилгээний зарчмыг сонгоно уу?
1. Эмчилгээг завсарлагаатай хийх
  2. Шууд хяналттай эмчлэх
  3. Нэг юмуу хоёр эмийг хосолж хэрэглэх
  4. Богино хугацаагаар эмчлэх
  5. Урт хугацааны эмчилгээний горимыг сонгох
- /51./ Цочмог В гепатит гэдгийг батлах оношын гол маркерийг тэмдэглэнэ үү?
- A. Анти HBc-IgM
  - B. Анти HA-IgM
  - C. Анти HD-IgM
  - D. HBsAg
  - E. Анти HE-IgM
- /52./ Архаг гепатит, элэгний цирроз улмаар хавдар үүсгэдэг вирусүүдийг тэмдэглэ
1. Гепатитын D вирус
  2. Гепатитын B вирус
  3. Гепатитын C вирус
  4. Гепатитын A вирус
  5. Гепатитын E вирус
- /53./ Респиратор-Синцитиаль вирусийн халдвар ямар замаар дамжин халдварлах вэ?
- A. Парентераль зам
  - B. Вирус тээгч
  - C. Агаар дуслын зам, ахуйн хавьтал, хамар залгиур, нүдний салстаар
  - D. Өвчтэй хүн
  - E. Агаар дуслын зам, хамар залгиур, нүдний салстаар
- /54./ Тархины цочмог хавангийн 3-р зэргийн үед цусны рСО<sub>2</sub>-ийн хэмжээ дараахь байдалтай байна.
- A. Хэвийн
  - B. Багасана
  - C. Ихэсэнэ
  - D. Янз бүрийн хэмжээнд
  - E. Хэт багасна.
- /55./ Вирус С гепатитын халдварын эх уурхайг тэмдэглэ.
- A. Халдвартай цус плазма
  - B. Өвчтэй хүн ба вирус тээгч
  - C. Өвчтэй амьтад
  - D. Бохирлогдсон зүү, тариур
  - E. Бэлгийн зам
- /56./ Улаан эсэргэний үед өвчтөний царай ямар байх вэ?
- A. Цонхигор
  - B. Улаан

- C. Улаан, хамар уруулын гурвалжин цагаан
- D. Нүд улайсан байна
- E. . Хэвийн

/57./ Бруцеллез өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй аргыг сонго.

- A. Өвчтэй хүнийг тусгаарлах
- B. Өвчтэй малыг тусгаарлах
- C. Эрүүл малыг вакцинжуулах
- D. Халдвар авсан хүнийг вакцинжуулах
- E. Эрүүл хүнийг вакцинжуулах

/58./ Цусан суулга өвчин нэг хүртлэх насны хүүхдэд ямар онцлогтой илэрдэг вэ?

1. 1. Өтгөн ус ихтэй, усгүйжилтэнд амархан орно
2. 2. Өтгөн салс ихтэй
3. 3. Бүдүүн гэдэсний үрэвслийн шинж бүдэг илэрсэн
4. 4. Дисбактериоз болох нь амархан
5. 5. Бөгсний амсар онгойно

/59./ Балнад өвчний үед ямар халууралт байх вэ?

1. Вундерлихийн
2. Килдюшевскийн
3. Боткины
4. Гектический
5. Халуунгүй

/60./ Менингоккийн мэнэнгийн үед нугасны усанд зонхилон илрэх өөрчлөлтүүдийг тэмдэглэ.

1. Даралт ихсэх
2. Булингартай болох
3. Уураг нэмэгдэх
4. Эсийн тоо цөөрөх
5. Тунгалаг эс зонхилон нэмэгдэх

/61./ Элэгний эсийг дутлыг илтгэх биохимийн үзүүлэлтүүдийг сонго.

1. Альбумин буурах
2. Протромбины индекс буурах
3. Бета – липопротейд буурах
4. Билирубин буурах
5. Сульма буурах

/62./ Герпес вирүсийн халдварыг дараахь байдлаар ангилдаг:

1. Анхдагч
2. Дахилтат
3. Түгмэл хэлбэр
4. Байршмал хэлбэр
5. Хавсарсан герпес

/63./ IgM –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?

1. Хожуу үед үүснэ
2. Эрт үед үүснэ
3. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
5. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй

/64./ Гахай хавдар өвчний ид үед эмнэл зүйн ямар шинжүүд илрэх вэ?

1. Ам ангайж болохгүй өвдөнө
2. Хоёр талын шүлсний булчирхай хавдсан
3. Бага зэрэг халуурна
4. Толгой таллаж хүчтэй өвдөнө.
5. Маш их хэмжээгээр бөөлжинө

/65./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг тэмдэглэнэ үү?

1. Толгой хүчтэй өвдөх
2. Цусархаг тууралт гарах
3. Олон удаа бөөлжих
4. Гэнэт өндөр халуурах



5. Ухаан алдах
- /66./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.
1. Нууц хугацаа 2-7 хоног
  2. Ангина илрэхгүй
  3. Тууралт нүүрнээс эхэлнэ
  4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
  5. Эрүүн дорхи лимфаденит болно
- /67./ Цусан суулга өвчний халдварын эх уурхай юу вэ?
- A. Өвчтэй хүн
  - B. Вирус тээгч
  - C. Нян тээгч
  - D. Өвчтэй хүн болон нян тээгчид
  - E. Өвчтэй хүн болон вирус тээгчид
- /68./ Улаанууд өвчний өвөрмөц шинж болох тунгалагийн булчирхайн томролт арьсны тууралт гарахаас хэдэн цагийн өмнө ихэвчлэн ажиглагдах вэ?
- A. 3-7 цаг
  - B. 5-10 цаг
  - C. 10-14 цаг
  - D. 24 цагийн дотор
  - E. 24-48 цаг
- /69./ Галзуу өвчний халдварын эх уурхай юу вэ?
- A. Өвчтэй хүн
  - B. Вирус тээгч хүн
  - C. Галзуу нохой
  - D. Галзуу тэмээ
  - E. Хулгана
- /70./ Гепатитын С вирусийн 1b генотип илэрсэн өвчтөнд интерферон болон рибавирины хосолсон эмчилгээг хэдий хугацаанд хийх заалттай вэ?
- A. 4 долоо хоног
  - B. 8 долоо хоног
  - C. 12 долоо хоног
  - D. 24 долоо хоног
  - E. 48 долоо хоног
- /71./ Улаан бурхны үүсгэгч ямар эсийг гэмтээх вэ?
- A. Эпители эс
  - B. Элэгний эс
  - C. Энтероцит эс
  - D. Улаан эс
  - E. Цагаан эс
- /72./ Сахуугийн үед хэрэглэгдэх өвөрмөц эмчилгээг заа
- A. Нянгийн эсрэг ийлдэс
  - B. Антибиотик
  - C. Иммуноглобулин
  - D. Сахуугийн хорын эсрэг ийлдэс
  - E. Гаммаглобулин
- /73./ Ёлом өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?
- A. Парамиксовирус
  - B. Стрептококк
  - C. Алтлаг стафилококк
  - D. Стафилококк эпидермис
  - E. Хламид
- /74./ Салымонеллууд хиама, махан бүтээгдэхүүн дотор ямар хугацаагаар амьд байж чадах вэ?
- A. 2 хоног
  - B. 3-10 хоног
  - C. 45 хоног.

- D. 180 хоног  
E. 15-45 хоног
- /75./ Халдвар хордлогын шокийн үеийн эмчилгээнд гепариныг хийх үе аль нь вэ?  
A. Гипокоагуляци  
B. Гиперкоагуляци  
C. Цитолиз  
D. Афибриногенеми  
E. Холестаза
- /76./ Тарваган тахал өвчний халдварыг гол тараагч эх уурхай юу вэ?  
A. Өвчтэй хүн, мэрэгч амьтад  
B. Нохой, шувуу  
C. Өвчтэй хүн, өвчлөөд нас барсан хүний цогцос, мэрэгч туулай, түүний сэг зэм  
D. Мэрэгч амьтад  
E. Өвчтэй хүн, нас барсан хүний цогцос
- /77./ Урвах тахал өвчний халдварын эх уурхай юу вэ?  
A. Өвчтэй хүн  
B. Мэрэгчид  
C. Ус  
D. Гэрийн тэжээмэл амьтад  
E. Бохир гар
- /78./ Амьсгалын цочмог халтай хам шинжийн халдварын эх уурхайг тэмдэглэнэ үү?  
A. A. Вирүс тээгч  
B. B. Өвчтэй хүн  
C. C. Нян тээгч  
D. D. Өвчтэй хүн болон вирүс тээгч
- /79./ Цочмог А гепатитын үед шарлалтын үеийн үргэлжлэх дундаж хугацааг тэмдэглэнэ үү?  
A. 1-7 хоног  
B. 2-14 хоног  
C. 2-3 долоо хоног  
D. 1-2 сар  
E. 1-3 сар
- /80./ Татрангийн үед илрэхгүй шинж аль нь вэ?  
A. Зажлуур булчингийн чангарал  
B. Мимик булчингийн чангарал  
C. Опистотонус  
D. Суулгалт  
E. Халууралт
- /81./ Менингококкийн менингитийн үүсгэгчийг тэмдэглэнэ үү?  
A. N. Gonorrhoeae  
B. N. Meningitidis  
C. N. Mucosa  
D. N. Flava  
E. N. Siccra
- /82./ Вирүст С гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийн бэлдмэл  
A. Аскорбины хүчил  
B. Эссенциале Форте  
C. Зовиракс  
D. Ацикловир  
E. Интерферон альфа
- /83./ Улаан эсэргэнэ өвчний үед хордлогын шинж өвчний хэд дэхь өдрөөс эхлэх вэ?  
A. Өвчний эхний өдрөөс  
B. Өвчний 4-5 дахь хоногоос  
C. Өвчний 7-8 дахь хоногоос  
D. Өвчний 10 дахь ахоногоос  
E. Өвчний 10-15 дахь хоногоос

- /84./ В гепатитын эдгэрэлтийг илтгэх эсрэг биеийг нэрлэнэ үү?
- A. Анти HBe
  - B. Анти-HBs
  - C. Анти HBc
  - D. Анти-HBcIgM
  - E. Анти HD
- /85./ Цусан суулга өвчний нууц хугацаа хэд хоног вэ?
- A. 2-3 цаг
  - B. 1-2 хоног
  - C. 2-3 хоног
  - D. 4-7 хоног
  - E. 7-10 хоног
- /86./ Улаанууд өвчний үед тунгалагийн булчирхайн томролт хэд хоног ажиглагдах вэ?
- A. 3-7 хоног
  - B. 7-9 хоног
  - C. 2 -3 долоо хоног
  - D. 3-4 долоо хоног
  - E. 4-5 долоо хоног
- /87./ Галзуу өвчний нууц хугацаа дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?
- A. 7-10 хоног
  - B. 10-14 хоног
  - C. 12-90 хоног
  - D. 14-28 хоног
  - E. 28-80 хоног
- /88./ Гепатитын С вирусийн 2a генотип илэрсэн өвчтөнд интерферон болон рибавирины хосолсон эмчилгээг хэдий хугацаанд хийх заалттай вэ?
- A. 4 долоо хоног
  - B. 8 долоо хоног
  - C. 12 долоо хоног
  - D. 24 долоо хоног
  - E. 48 долоо хоног
- /89./ Улаан бурхны үед гарах өвөрмөц шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?
- A. Пастиагийн шинж
  - B. Бельский- Филатов- Копликийн шинж
  - C. Ашнерийн шинж
  - D. Филлиповичийн шинж
  - E. Падалкийн шинж
- /90./ Елом өвчний халдварын эх уурхай юу вэ?
- A. Стафилококк тээгч эрүүл хүмүүс
  - B. Улаан бурхан бүхий өвчтөн
  - C. Стрептококк ангины өвчтэй хүн
  - D. Архаг гепатиттай өвчтөн
  - E. Сүрьеэтэй өвчтөн
- /91./ Сальмонеллез өвчтэй хүн өвчний аль шатанд хамгийн их халдвартай байх вэ?
- A. нууц үедээ
  - B. өвчний ид үед
  - C. эдгэрэх үед
  - D. дахих үед
  - E. бүх үеийн турш
- /92./ Халдвар хордлогын шокийн үед илэрдэг нэгэн өвөрмөц шинж болох Гведалийн шинжийг тодорхойлно уу?
- A. Хамар уруулын гурвалжин хөхрөх шинж
  - B. Арьсан дээр дарахад цайх шинж
  - C. Арьсан дарахад улайх шинж
  - D. Хөлийн үзүүр цайрч хөхрөх шинж
  - E. . Арьс эрээнтэх шинж

- /93./ Тарваган тахал өвчний эмнэлзүйн хэлбэрүүдийг сонгоно уу?
- A. Арьсны болон уушгины хэлбэр
  - B. Уушгины болон гэдэсний хэлбэр
  - C. Арьсны, булчирхайн, уушгины, үжил, гэдэсний болон залгиур хоолойн хэлбэр
  - D. Арьсны, уушгины болон гэдэсний
  - E. Арьсны, уушгины, гэдэсний болон үжилт хэлбэр
- /94./ Урвах тахлын үед баасны шинж чанар ямар байх вэ?
- A. Бага хэмжээтэй, хэлбэрээ алдаагүй
  - B. Их хэмжээний хар ногоон
  - C. Цус, залхагны хольцтой
  - D. Цагаан будааны шүүс шиг
  - E. Жимсний чанамал шиг улаан
- /95./ Амьсгалын цочмог халтай хам шинжийн халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?
- A. А. Вирүс тээгч
  - B. В. Өвчтөнөөс агаарт цацарсан дуслууд
  - C. С. Хоол боловсруулах зам
  - D. D. Өвчтэй хүн болон вирүс тээгч
  - E. E. Парентераль зам
- /96./ Халдварт мононуклеоз өвчний эх уурхай юу вэ?
- A. Өвчтэй мал
  - B. Өвчтэй хүн ба вирус тээгч
  - C. Өвчтэй хүн ба мал
  - D. Эрүүл вирус тээгч
  - E. Ялаа, шумуул
- /97./ Респиратор-Синцитиаль вирүсийн халдварын нууц хугацааг тэмдэглэнэ үү?
- A. Хэдэн цаг
  - B. 2-3 хоног
  - C. 4-6 хоног
  - D. 5-7 хоног
  - E. 7-10 хоног
- /98./ Менингококкийн менингитийн халдварын эх уурхай юу вэ?
- A. Вирүс тээгч
  - B. Нян тээгч
  - C. Өвчтэй хүн болон нян тээгч
  - D. Өвчтэй мал амьтад
  - E. E. Өвчтэй хүн
- /99./ Улаан эсэргэнэ өвчний үед тууралт дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?
- A. эхний өдөр
  - B. эхний өдрийн сүүлч 3 дахь өдрийн эхэн үе
  - C. 3 -5 хоног
  - D. 3-7 хоног
  - E. 7-10 хоног
- /100./ Гахай хавдар өвчнийг Н.И.Нисевич, В.Ф.Учайкин нарын ангилалаар хэрхэн ангилах вэ?
- A. Булчирхайн
  - B. Мэдрэлийн
  - C. Хавсарсан
  - D. Хөнгөн
  - E. Дунд
- /101./ Цусан суулга өвчин ямар замаар дамжин халдварлах вэ?
- A. Парентераль зам
  - B. Өтгөн-мөр амаар
  - C. Цусаар
  - D. Хачгинд хазуулах
  - E. Агаар дуслын зам

/102./ Улаанууд өвчний үед насанд хүрэгчдэд тунгалагийн булчирхай ямар дараалалаар цочих нь ихэвчлэн ажиглагддаг вэ?

- A. Хүзүүний урд болон дагзны булчирхай
- B. Чихний ойролцоох булчирхай, дагзны арын болон хүзүүний арын булчирхай
- C. Хүзүүний урд, хүзүүний ар болон дагзны булчирхай
- D. Дагзны булчирхай болон эрүүн доорхи булчирхай
- E. Эрүүн доорхи болон дагзны булчирхай

/103./ Боом өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Спирохет
- B. Ортомиксовирус
- C. Рабдовирус
- D. Бацилла антрацис
- E. Реовирус

/104./ Улаанууд өвчний үүсгэгчийг тэмдэглэнэ үү?

- A. Picornaviridae
- B. Herpesviridae
- C. Hepadnaviridae
- D. Rubiviridae
- E. Paramixoviridae

/105./ Сахуугийн хордлогот хэлбэрийн 1-р зэргийн үед хүзүүний хаван ямар хэмжээтэй байх вэ?

- A. Эгэм хүртэл
- B. Харахад мэдэгдэх төдий
- C. Хүзүүний дунд хүрсэн
- D. Эгэмнээс доош орсон
- E. Тэмтрэхэд мэдрэгдэнэ

/106./ Ёлом өвчний үед арьсанд гарах өөрчлөлтийг тэмдэглэнэ үү?

- A. Цэврүү
- B. Улайлт
- C. Хаван
- D. Загатнах
- E. Дээрх бүх өөрчлөлт илэрнэ

/107./ Томуу өвчний халдварын эх уурхай юу вэ?

- A. Өвчтэй хүн
- B. Өвчтэй хүн, вирус тээгч
- C. Агаар дуслын зам
- D. Өвчтэй хүн болон нян тээгчид
- E. Хоол боловсруулах зам

/108./ Аллоговрийн коэффициент гэж юу вэ?

A. 1 минутанд амьсгалж байгаа амьсгалын тоог судасны цохилтын тоонд харьцуулсан хэмжээ

- B. Зүрхний цохилтын тоог артерийн дээд даралтанд харьцуулсан хэмжээ
- C. Артерийн доод даралтын хэмжээг судасны цохилтын тоонд харьцуулсан хэмжээ
- D. Судасны цохилтын тоог амьсгалын тоонд харьцуулсан хэмжээ
- E. Артерийн дээд даралтыг артерийн доод даралтанд харьцуулсан хэмжээ

/109./ Тарваган тахал өвчний нууц хугацаа дунджаар хэд хоног үргэлжлэх вэ?

- A. 1-2 хоног
- B. 1- 4 хоног
- C. 2-3 хоног
- D. 5-10 хоног
- E. 14-30 хоног

/110./ Амьсгалын цочмог халтай хам шинжийн үеийн гол шинжийг тэмдэглэнэ үү?

- A. Хамар битүүрэх
- B. Амьсгал дутлын дестресс хам шинж шинж
- C. Хяхнасан амьсгал
- D. Толгой өвдөх

- Е. Хоолонд дургүй
- /111./ Цочмог А гепатитаар өвчлөгсдийн хэдэн хувь нь бүрэн эдгэрдэг вэ?
- A. 50-60%
  - B. 65%
  - C. 75%
  - D. 80%
  - E. 90%
- /112./ Эпстайн-Баррын вирус ямар эсийг сонгомлоор гэмтээх вэ?
- A. Макрофаги
  - B. Т-лимфоцит
  - C. В -лимфоцит
  - D. Эритроцит
  - E. Лейкоцит
- /113./ Респиратор-Синцитиаль вирусийн халдварын эмнэлзүйн гол шинж тэмдэгийг тэмдэглэнэ үү?
- A. Нус гоожих, халуурах
  - B. Халуурах, толгой өвдөх
  - C. Мөгөөрсөн хоолойн үрэвсэл
  - D. Төвөнхийн үрэвсэл, Халуурах
  - E. Уушги- гуурсан хоолойн хам шинж
- /114./ Менингококкийн менингитийн халдвар дамжих замыг тэмдэглэнэ үү?
- A. Агаар дуслаар
  - B. Ахуйн хавьтал
  - C. Хоол хүнс
  - D. Бэлгийн зам
  - E. Парентераль зам
- /115./ Вирус С гепатит гэдгийг батлах оношийн маркерийг тэмдэглэ
- A. HBcAg/+/
  - B. anti- HBc-IgM /-/
  - C. HCV RNA /+/
  - D. anti- HCV /+/
  - E. HBsAg /+/
- /116./ Гахай хавдар өвчнийг булчирхайн томролтийн зэргээр хэд ангилах вэ?
- A. 2
  - B. 3
  - C. 4
  - D. Хөнгөн
  - E. Дунд
- /117./ В гепатитын үүсгэгчийг тэмдэглэ
- A. РНХ бүхий Флавирус
  - B. ДНХ бүхий Пикарновирис
  - C. ДНХ агуулсан гепадна вирус
  - D. РНХ агуулсан Калицивирус
  - E. РНХ агуулсан Дельта вирус
- /118./ Цусан суулга өвчний үед эмгэг өөрчлөлт аль хэсэгт байх вэ?
- A. Нарийн гэдэсний төгсгөл хэсэгт
  - B. Бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт
  - C. Хөндлөн гэдэс
  - D. Ходоод
  - E. Бүдүүн гэдэсний төгсгөл хэсэгт
- /119./ Боом өвчин хүний бие махбодид ямар замаар тархах вэ?
- A. Цусаар
  - B. Лимфээр
  - C. Периневраль шингэнээр
  - D. Гэмтсэн арьс салстаар
  - E. Холимог замаар

- /120./ Гепатитын С вирусийн халдвараас яаж урьдчилан сэргийлэх вэ?
- Төрсний дараа 24 цагийн дотор вакцин хийнэ
  - 2,3,4 сартайд нь вакцин хийнэ.
  - Өвөрмөц урьдчилан сэргийлэлт байхгүй
  - 2,3,4 настайд нь вакцин хийнэ
  - 8,16 насанд нь вакцин хийнэ
- /121./ Төвөнхийн сахуугийн эмнэл зүйн шинжүүд юу вэ?
- 38 хэм хүртэл халуурна
  - Хоолой сөөж ханиана
  - Төвөнхийн салстад зузаан өнгөр тогтдог
  - Гүйлсэн булчирхай, хүүхэн хэл зузаан саарал өнгөртэй
  - Гүйлсэн булчирай эмзэглэлтэй
- /122./ Архаг В гепатитын үед Интерферон эмчилгээ хийх үзүүлэлтүүдийг сонго.
- Алат фермент хэвийн байх
  - HBs Ag / + /
  - Тимол өндөр байх
  - АлАт ферментийн идэвх 2-5 дахин их байх
  - Альбумины хэмжээ буурах
- /123./ Хиамдал өвчний үүсгэгчийн хорыг..... илрүүлнэ
- Ходоод угаасан усанд
  - Хоолны үлдцэнд
  - Бөөлжисэнд
  - Өтгөнд
  - Цусанд
- /124./ Балнад өвчний халууралтын онцлог шинжүүдийг сонгоно уу?
- Өдөр ирэх тутам даамжирна
  - Хөлрөхгүй
  - Арьс хуурай
  - Халуунтай тохирсон тахикарди илэрнэ
  - Чичирнэ, хөлөрнө
- /125./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг нэрлэ
- Толгой хүчтэй өвдөх
  - Цусархаг тууралт гарах
  - Олон удаа бөөлжих
  - Гэнэт өндөр халуурах
  - Ухаан алдах
- /126./ Татрангийн өвөрмөц эмчилгээнд дараах бэлдмэлүүд орно:
- Тайвшруулах, таталтын эсрэг бэлдмэлүүд
  - Татрангийн хорын эсрэг ийлдэс
  - Антибиотик
  - Татрангийн иммуноглобулин
  - Сульфаниламид
- /127./ Хиамдал өвчин үүсэх нөхцөл бол.....
- Нөөшилсэн мөөг идэх
  - Нөөшилсэн өргөст хэмх идэх
  - Утсан махан бүтээгдэхүүн идэх
  - Жимсний чанамал идэх
  - Жимсний шүүс уух
- /128./ Сальмонеллезын ходоод гэдэсний хэлбэрт орохгүй хувилбарыг сонго.
- Гастрит
  - Балнад төст
  - Гастроэнтерит
  - Идээт үжил
  - Гастро-энтероколит
- /129./ Халдвар хордлогын шокийн эмнэл зүйн зэргийн шалгуурт орох үзүүлэлтүүдийг тэмдэглэ.

1. Цусархаг тууралтын байдал
  2. Артерийн даралтын түвшин болон Гведалийн шинж
  3. Шээсний хэмжээ
  4. Суулгалтын тоо
  5. Гэдэс базлалтын тоо
- /130./ Хүний биеийн өвөрмөц бус хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?
1. Арьс салстын хамгаалах урвал,
  2. Лизоцим ба ходоодны хүчил
  3. Амьсгалын замын намираа хучуур эд
  4. Т- лимфоцит
  5. Эсрэг бие
- /131./ Сахуугийн үед элбэг тохиолдох хүндрэлүүдийг заа.
1. Гломерулонефрит
  2. Миокардит
  3. Синовит
  4. Нефрит
  5. Кератит
- /132./ Varicella Zoster вирусийн халдварын гаж хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Том цэврүүт хэлбэр
  2. Үхжилт хэлбэр
  3. Цусархаг хэлбэр
  4. Хөнгөн хэлбэр
  5. Хүнд хэлбэр
- /133./ Герпес вирусийн оношлогоонд лабораторийн дараахь аргуудыг хэрэглэнэ
1. Ийлдэс судлалын
  2. Вирус судлалын
  3. Эс судлалын
  4. Нян судлалын
  5. Биохимийн
- /134./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн эмчилгээг тэмдэглэ
1. УВЧ-ээр шарах
  2. Бүлээн ба спиртэн бигнүүр
  3. Шүлс бага ялгаруулах шингэвтэр хоол
  4. Хацарт хүйтэн жин
  5. Цус тогтоох эмчилгээ зайлшгүй хийнэ
- /135./ Улаан эсэргэнэ өвчтөний царай ямар байх вэ?
1. Цонхигор
  2. Хацар нь улайсан
  3. Хамар уруулын гурвалжин хөх
  4. Хамар уруулын гурвалжин цагаан
  5. Зовхи хавдсан
- /136./ Тархины цочмог хавангийн зэргийг дараахь шинжүүд илэрхийлнэ
1. Ухаан санааны байдал
  2. Хүүхэн харааны урвал
  3. Мэнэнгийн шинжийн илрэх эрчим болон рефлекс
  4. Тууралтын байдал
  5. Халууралт
- /137./ Архаг гепатит, элэгний цирроз, хавдарын шалтгаан болдоггүй вирусүүдийг тэмдэглэ.
1. Гепатитын С вирус
  2. Гепатитын А вирус
  3. Эпштейн Баррын вирус
  4. Гепатитын Е вирус
  5. Гепатитын D вирус
- /138./ Сахуугийн савханцар ямар хор фермент ялгаруулдаг вэ?
1. Гиалуранидаза
  2. Нейраминадаза



3. Гадар хор
  4. Дотор хор
  5. Цистиназа
- /139./ Томуу өвчний эхлэл үеийн шинжүүдийг нэрлэ.
1. 38.5-40 хэм хүрч халуурна
  2. Толгой өвдөнө
  3. Үе мөч, булчингаар шархирч өвдөнө
  4. Ханиалгана
  5. Хамар битүүрнэ
- /140./ В гепатитаас сэргийлэх тарилгыг тарих насыг зөв сонго.
1. Төрсний дараа 24 цагийн дотор
  2. 2 сартайд
  3. 3 сартайд
  4. 4 сартайд
  5. Бүгд зөв
